

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn

Аудитор: О.Энхтөр

Утас: 95343496 Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ТАЙШИР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.СУМЪЯАБАЗАР ТАНАА

2025. 03. 25 № 155

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тайшир сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шагнал, урамшуулалд 4.6 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан,
- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 66.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

822511000460

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 483.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 694.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 211.1 сая төгрөгөөр буюу 43.7 хувиар давуулан биелүүлжээ.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,361.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Тайлант онд нийт 134.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Засаг даргын Тамгын газар 17.0 сая төгрөгийн шатахууны болон бусад өглөг, Ерөнхий боловсролын сургууль 44.7 сая төгрөгийн түлш халаалтын, Соёлын төв 22.7 сая төгрөгийн халаалтын өр төлбөртэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 20 зорилт, 141 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 85.6 хувьтай үнэлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	725,519.1	1,007,103.8
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	385,795.4	539,667.8
3	АВЛАГА	122,759.1	220,427.2
4	БАРАА МАТЕРИАЛ	175,037.2	191,964.3
5	НӨӨЦИЙН БАРАА	24,567.5	41,394.5
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	17,360.0	13,650.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,601,219.0	4,265,450.9
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,601,219.0	4,265,450.9
9	Биет хөрөнгө	1,548,060.1	4,213,251.8
10	Биет бус хөрөнгө	53,158.9	52,199.2
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,326,738.1	5,272,554.7
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	41,932.8	134,274.5
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,932.8	134,274.5
14	Өглөг	41,932.8	134,274.5
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,284,805.3	5,138,280.2
16	Засгийн газрын хувь оролцоо	2,284,805.3	5,138,280.2
17	Засгийн газрын оруулсан капитал	522,743.0	522,743.0
18	Хуримтлагдсан үр дүн	1,490,476.4	4,343,951.3
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,585.9	271,585.9
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,326,738.1	5,272,554.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,312,908.5	4,853,710.6
2	ТАТВАРЫН ОРЛОГО	343,917.8	692,889.6
3	Орлогын албан татвар	268,542.1	401,779.5
4	Хувь хүний орлогын албан татвар	294,844.1	428,637.3
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-26,302.0	-26,857.8
6	Хөрөнгийн албан татвар	43,440.7	59,396.2
7	Бусад татвар, төлбөр, хураамж	31,935.0	231,714.0
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	448,072.3	4,160,821.0
9	Тусламжийн орлого	-	815,267.8
10	Тодруулга	1,520,918.5	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,570,094.3	1,678,865.4
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,570,094.3	1,678,865.4
13	Тодруулга	1,506,394.3	1,678,501.4
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,897.4	665,514.8

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,752.3	80,329.6
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	426,259.4	491,747.1
17	Хангамж, бараа материалын зардал	50,909.8	37,474.0
18	Эд хогшил, урсгал засварын зардал	22,281.5	4,120.3
19	Томилолт, зочны зардал	5,598.0	5,040.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,385.1	4,887.4
21	Бараа үйлчилгээний бусад зардал	352,310.8	389,388.4
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,700.1	364.0
23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	742,814.2	3,174,845.2
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	700.0
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	343,471.0	304,710.3
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-343,471.0	-304,010.3
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	399,343.2	2,870,834.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцосны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	1,885,462.1	1,885,462.1
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,885,462.1	1,885,462.1
3	Тайлант үеийн үр дүн	399,343.2	399,343.2
4	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,284,805.3	2,284,805.3
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,284,805.3	2,284,805.3
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(17,360.0)	(17,360.0)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,267,445.3	2,267,445.3
8	Тайлант үеийн үр дүн	2,870,834.9	2,870,834.9
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,138,280.2	5,138,280.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,935,957.7	1,904,271.8
2	ТАТВАРЫН ОРЛОГО	343,917.8	692,889.6
3	Орлогын албан татвар	268,542.1	401,779.5
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(26,302.0)	(26,857.8)
5	Хөрөнгийн албан татвар	43,440.7	59,396.2
6	Бусад татвар, төлбөр, хураамж	31,935.0	231,714.0
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,315.9	10,919.4
8	Газрын төлбөр	26,820.4	83,586.7
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	798.7	137,207.9
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,121.4	1,211,382.2

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

11	Нийтлэг татварын бус орлого	71,121.4	69,330.1
12	Тусламжийн орлого	-	815,267.8
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	326,784.3
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,520,918.5	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,398,768.4	1,284,832.1
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,398,768.4	1,284,832.1
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,333,876.3	1,284,468.1
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,028.1	683,662.4
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,922.0	80,329.6
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	426,259.4	424,034.3
21	Хангамж, бараа материалын зардал	46,156.1	29,455.9
22	Эд хогшил, урсгал засварын зардал	26,780.5	1,000.0
23	Томилолт, зочны зардал	5,598.0	5,040.0
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,385.1	4,887.4
25	Бараа үйлчилгээний бусад зардал	161,747.2	56,058.6
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,892.1	364.0
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	537,189.3	619,439.7
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	426,195.7	325,567.3
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	426,195.7	325,567.3
30	Дотоод эх үүсвэрээр	426,195.7	325,567.3
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(426,195.7)	(325,567.3)
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	140,000.0
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(140,000.0)
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	110,993.6	153,872.4
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	274,801.8	385,795.4
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	385,795.4	539,667.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,705,521.9	1,889,987.9	(184,466.0)	110.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	481,228.3	692,889.6	(211,661.3)	144.0
320001	Орон нутгийн төсвөөс	297,010.1	401,779.5	(104,769.4)	135.3
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	323,867.9	428,637.3	(104,769.4)	132.3
34	Оны эхний үлдэгдлээс	268,521.5	374,219.1	(105,697.6)	139.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,762.4	12,130.2	(4,367.8)	156.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	992.0	1,532.0	(540.0)	154.4

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,034.5	13,904.9	1,129.6	92.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,875,927.8	1,729,215.5	146,712.3	92.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,307,722.1	1,263,648.2	44,073.9	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,305,513.5	1,263,284.2	42,229.3	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,420.9	683,662.4	1,758.5	99.7
210101	Үндсэн цалин	429,481.0	367,046.9	62,434.1	85.5
210102	Нэмэгдэл	215,939.9	262,716.2	(46,776.3)	121.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,677.6	80,329.6	5,348.0	93.8
210201	Тэтгэврийн даатгал	56,056.8	54,876.8	1,180.0	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	7,405.2	6,538.8	866.4	88.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,702.6	3,269.4	433.2	88.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,702.6	3,119.4	583.2	84.2
210205	Эрүүл мэндийн даатгал	14,810.4	12,525.3	2,285.1	84.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	428,579.3	424,034.2	4,545.1	98.9
210301	Гэрэл, цахилгаан	25,318.8	23,395.3	1,923.5	92.4
210302	Түлш, халаалт	403,260.5	400,639.0	2,621.5	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	39,500.0	28,157.5	11,342.5	71.3
210401	Бичиг хэрэг	5,000.0	3,230.8	1,769.3	64.6
210402	Тээвэр, шатахуун	29,200.0	20,010.5	9,189.5	68.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200.0	3,845.5	354.5	91.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100.0	70.7	29.3	70.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.0	1,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.0	1,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,000.0	1,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,000.0	5,040.0	1,960.0	72.0
210702	Дотоод албан томилолт	7,000.0	5,040.0	1,960.0	72.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,475.6	2,255.4	3,220.2	41.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,184.6	174.0	2,010.6	8.0
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	403.2	596.8	40.3
210803	Даатгалын үйлчилгээ	650.0	294.0	356.0	45.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177.0	164.9	12.1	93.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	149.0	88.0	61.0	59.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,030.0	1,030.0	-	100.0
210807	Газрын төлбөр	285.0	101.2	183.8	35.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,860.1	38,805.2	14,054.9	73.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,060.1	37,151.0	12,909.1	74.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800.0	1,654.2	1,145.8	59.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,208.6	364.0	1,844.6	16.5

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,208.6	364.0	1,844.6	16.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,499.8	325,567.3	74,932.5	81.3
223001	Бусад хөрөнгө	400,499.8	325,567.3	74,932.5	81.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	167,705.9	140,000.0	27,705.9	83.5
230001	Эргэж төлөгдөх зээл	167,705.9	140,000.0	27,705.9	83.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	385,795.4	(385,795.4)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	539,667.8	(539,667.8)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Дансны нэр, төрөл	Дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,418.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,418.9
122	Тусламжийн орлого	13,418.9
1221	Хандив тусламж /дотоод/	13,418.9
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,418.9
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,383.9
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,383.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,383.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,383.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,298.5
210402	Тээвэр, шатахуун	1,298.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,632.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,632.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,453.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,453.5
4	Төвлөрүүлэх шилжүүлэг	35.0

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба сумын ИТХ, ХХС, БХНСС, ОНХС, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 1 алдааг залруулж, 36.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 24.0 сая төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналыг 204.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 8 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.

3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 4.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага бөгөөд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг 61.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4.6 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс, 1 албан шаардлага, 4.6 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.3.1 Албан шаардлага

Нэг. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 61.4 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, 0.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36.4 сая төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах заалт албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 24.1 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1.2 сая төгрөгийг мөсний баярын шагналд, 3.4 сая төгрөгийг Улаанбаатар хотод сар шинийн золголтын гарын бэлгийн зардалд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй,

хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Үүнээс		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайшир сумын ЗДТГ	1	10,000.0	1	10,000.0	-	-	1	10,000.0	-	-	-	-	-	-
Тайшир сумын ОНХС	6	197,705.1	1	101,360.5	5	96,344.6	-	-	-	-	-	-	-	-
Тайшир сумын ХХС	2	6,303.5	1	6,205.0	1	98.5	2	6,303.5	-	-	-	-	-	-
Дүн	9	214,008.6	3	117,565.5	6	96,443.1	3	16,303.5	-	-	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Өөрчлөлт		Хязгаралтай		Сөрөг		Дүнгэлт өгөхөөс татгалзах түвэрт		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайшир сумын ТТЗ	1	1	1	1	-	-	-	-	3	4,602.0	-	-	-	-	1	4,602.0	1	1	-	-
Тайшир сумын ЗДТГ	1	1	1	60,541.0	-	-	1	36,447.9	3	60,541.0	-	-	1	24,093.1	1	24,093.1	1	1	-	-
Тайшир сумын ИТХ	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Тайшир сумын ОНХС	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Тайшир сумын БХНСС	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	5	-	2	-	3	65,143.0	-	-	6	65,143.0	-	-	1	36,447.9	2	28,695.1	2	2	-	-

Тайшир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийсэн хэлбэр	Өөрчлөлтийг Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ		1				1		
	НИЙТ		1			1	1		